



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2023 оны 02 сарын 10 өдөр


Дугаар 15

Дархан сум

Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг  
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.12, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай 77 дугаар зүйлийн 77.1, 77.4, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 75 дугаар зүйлийн 75.4, 79 дүгээр зүйлийн 79.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. "Дархан-Ус суваг" Хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 27, 28, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 03 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



Дархан-Уул аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын 2023 оны 6. дүгээр сарын 10-ны  
өдрийн 16.. дүгээр тогтоолын хавсралт



**"Дархан-ус суваг" Хувьцаат компанийн  
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд**

| № | Гишүүдийн нэрс | Албан тушаал   |
|---|----------------|--|
| 1 | Г.Эрдэнэсүх    | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч            |
| 2 | С.Ганзориг     | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч            |
| 3 | Ж.Дорждэрэм    | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч            |
| 4 | О.Хүрэлчuluун  | Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга                   |
| 5 | З.Эрдэнэбат    | Дархан хотын тохижилт үйлчилгээний газрын дарга            |
| 6 | Ч.Энхбат       | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга |

**Хараат бус гишүүдийн нэрс**

|   |              |   |
|---|--------------|---|
| 7 | Ч.Оюунчuluун | Дархан-Уул аймгийн<br>Шарын гол сумын 1 дүгээр багийн иргэн |
| 8 | Д.Бат-Эрдэнэ | Дархан-Уул аймгийн<br>Дархан сумын 10 дугаар багийн иргэн   |
| 9 | Х.Отгонбаяр  | Дархан-Уул аймгийн<br>Дархан сумын 10 дугаар багийн иргэн   |

\_\_\_\_\_oOo\_\_\_\_\_



**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 10 өдөр

Дугаар A/02

Дархан

**Хуралдаанаар хэлэлцэх асуудал  
батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 48 дугаар зүйлийн 48.3, 52 дугаар зүйлийн 52.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дахь удаагийн сонгуулийн ээлжит 15 дугаар хуралдаанаар дараах асуудлуудыг хэлэлцүүлсүгэй.

1. Орон нутгийн өөрийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам, төлбөрийн хэмжээг тогтоох тухай
2. Үндсэн хөрөнгө шилжүүлэх, зөвшөөрөл олгох тухай (3 тогтоол)
3. Үндсэн хөрөнгө бүртгэх, зөвшөөрөл олгох тухай (2 тогтоол)
4. Хэсэгчилсэн өрөнхий төлөвлөгөө батлах тухай
5. “Нээлттэй Дархан” хөтөлбөр батлах тухай
6. Нийтийн эзэмшлийн газар, барилга, байгууламж дээр зар сурталчилгаа байрлуулах зөвшөөрөл олгох журам батлах тухай
7. Автотээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хувь, хэмжээг тогтоох тухай
8. Бичил худалдаа, ажил үйлчилгээний орлогын албан татварын хувь хэмжээг тогтоох тухай
9. Газрын нэгдмэл сангийн тайланг дүгнэх тухай
10. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт
11. Ёс зүйн хорооны гишүүдийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай
12. Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай (ДАШЦогцолбор ХХК)
13. ТУЗ-д ажиллах орон нутгийн төлөөллийг батлах тухай (ДАШЦогцолбор ХХК)
14. ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай (Дархан-Ус суваг ХК)

15. Салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн батлах тухай (ГХУСАЗСЗ)
16. Олон нийтийн цагдаагийн тоо, урамшууллын хэмжээг тогтоох тухай
17. Урамшууллын хэмжээг тогтоох тухай (Иргэний зөвлөл)
18. Гамшигийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн гишүүний бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн батлах тухай
19. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай /аймгийн ИТХ/

Хоёр. Хуралдааны бэлтгэл, зохион байгуулалтыг хангаж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Ч.Энхбат), аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (О.Хүрэлчuluун) нарт үүрэг болгосугай.





ДАРХАН-УУЛ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 01

Дархан

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дахь удаагийн сонгуулийн ээлжит 15 дугаар хуралдаан мөн өдрийн 09.15 минутад аймгийн ЗДТГ-ын хуралдааны танхимд эхлэв.

Аймгийн ИТХ-ын дарга С.Насанбат хуралдааныг нээж үг хэлж, хуралдаанд оролцвол зохих 33 төлөөлөгчөөс 22 төлөөлөгч оролцож, Д.Амарсанаа, Б.Жавхлан, Б.Хадбаатар, З.Эрдэнэбат, А.Янжмаа нар чөлөөтэй, Д.Батжаргал, С.Батжаргал, Ш.Бат-Өлзий, Б.Буяндуүрэн, Г.Мөнхбат, Т.Тулгаа нар өвчтэй, ирц 66,7 хувтай байгааг танилцуулан хуралдааныг нээх санал гаргахад төлөөлөгчид бүгд зөвшөөрч гар өргөв.

**Төрийн дуулалт эгшиглэв.**

Аймгийн ИТХ-ын төлөөлөгчид болон хуралдаанд оролцож буй хэлтэс, агентлагийн дарга нар, хэлэлцэх асуудалтай холбоотой оролцож буй албан тушаалтнууд бүгд босч номхон зогсож хүндэтгэл үзүүллээ.

Хуралдааны дарга – Аймгийн ИТХ-ын ээлжит 15 дугаар хуралдааны дэд даргыг сонгоё. Өнөөдрийн хуралдааны дэд даргаар хэнийг сонгох санал хэнд байна вэ гэв.

Д.Хүрэлчимэг (аймгийн ИТХ-ын төлөөлөгч) - Хуралдааны дэд даргаар төлөөлөгч Н.Чимэддоржийг сонгох саналтай байна.

Хуралдааны дарга – Хуралдааны дэд даргаар төлөөлөгч Н.Чимэддоржийг сонгох санал гарлаа. Төлөөлөгчдөд өөр санал байна уу? гэхэд өөр санал гаралаа бүгд хуралдаанд оролцож буй төлөөлөгчдийн 100 хувийн саналаар төлөөлөгч Н.Чимэддоржийг дэмжив.

Хуралдааны дарга – Хуралдааны дэд даргаар сонгогдсон төлөөлөгч Н.Чимэддоржийг хуралдааны удирдлагын байранд урьж суулгав.

Хуралдааны дарга – Хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг танилцуулан төлөөлөгчдөөс асуулт, санал байна уу гэхэд төлөөлөгчдөөс гар өргөв.

Д.Элдэвсайхан (аймгийн ИТХ-ын төлөөлөгч) - Хэлэлцэх асуудлын 4-т байгаа. Хэсэгчилсэн өрөнхий төлөвлөгөөг батлах биш дэмжсэн тогтоол гарах ёстой юм биш үү?

П.Батсүх (аймгийн ХБТХОХ-ийн дарга) - Хуулиндаа батлах гэж байгаа юм.

Хууль шүүхийн асуудал дуусаад ажил жигдэрээд ирэхээр шинэ нөхцөл байдалдаа тааруулаад дурмээ сайн боловсруулаад батлуулья гэв.

Хуралдааны дарга – Θөр асуулт, санал гараагүй тул асуулт, саналыг таслах уу гэхэд төлөөлөгчид бүгд гар өргөж зөвшөөрснөөр асуулт, саналыг таслав.

#### ХЭЛЭЛЦСЭН нь 14:

Хуралдааны дарга - ТҮЗ-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай (Дархан-Ус суваг ХК) илтгэлийг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Ч.Энхбат илтгэхийг мэдэгдэв.

ТҮЗ-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай (Дархан-Ус суваг ХК) илтгэлийг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Ч.Энхбат илтгэв. 3 минут.

Хуралдааны дарга – Хэлэлцүүлсэн асуудалтай холбогдуулан асуулт, хариулт явагдахыг мэдэгдэв.

#### СОНССОН нь 14:

П.Эрдэнэбат (аймгийн ИТХ-ын төлөөлөгч) – Сая Ч.Энхбат даргын хэлж байгаа тайлбарыг сонслоо. ТҮЗ-ын бүрэлдэхүүнийг харахад өмнөхөөс зарим хүмүүс нь байна. Ямар учраас миний бие хасагдаад, ямар шалтгаанаар эдгээр хүмүүс томилогдсон юм бэ. Чөлөөлөгдөж байгаа учир шалтгааныхаа тайлбарыг сонсоёе. Надад бол энд үлдэх гээд байх сонирхол алга. Өчигдөр хуралдааны материал хүлээж аваад харахад ийм асуудал байхаар нь ямар учиртай юм бол гэж бодоод өнгөрсөн. Эдгээр хүмүүс 2 жил болоод сунгагдаж байгаа юм байна. Би бол 2 сар болоод чөлөөлөгдөж байх шиг байна. Өмнөх хурлаар хэлтэс, агентлагийн дарга нарын өмнө миний нэрийг цоллож байгаад томилох шиг болсон. Нэг талаараа би Дархан-Ус суваг ХК-ийн ТҮЗ-ийн аудитын хорооны дарга, талийгч дарга настай нь 7 жил хамтарч ажиллаж байсан. Энэ байгууллагын талаар чамгүй сайн мэднээ. Энэ байгууллагын алдагдлыг бууруулах чиглэлээр тус дэм болох гээд чадлын хирээр ажилласан гэж өөрийгөө ойлгодог. Мэдсэн бол өмнөх хуралдаанаар томилох үед нь татгалздаг байж. Хүнээр тоглож байгаа юм шиг сонин санагдлаа. Гэхдээ энэ хэдэн сарын хугацаанд Г.Эрдэнэбат даргад ч нэмэр болох гээд чадлаараа ажилласан. Хамтарч ажилласан ТҮЗ-ын гишүүддээ баярлалаа.

Б.Азжаргал (аймгийн Засаг дарга) – Янз бүрийн байдлаар оруулаад, гаргаад тоглоом шоглоом хийж байгаа асуудал биш. Аудитын газраас иргэний төлөөллүүдийг оролцуулах ёстой гэдэг зөвлөмж ирсний дагуу тэр зарчмаар өөрчлөлт орсон. Төрийн байгууллагыг төлөөлж аймгийн ЗДТГ-аас хүнээ оруулсан. Гэх мэтчилэн субъект болгоноос санал ирээд оруулсан асуудал юм. Үүнийг зөвөөр ойлгож, зөв хүлээж аваарай.

Хуралдааны дарга – 1. Хугацаа дууссан. 2. Аудитын газраас зөвлөмж ирсэн. Зөвлөмж нь хэрэгжүүлэх хугацаатай ирсэн боловч хугацаа нь жаахан өнгөрчихсөн байгаа юм.

#### ХЭЛЭЛЦСЭН нь 15, 16, 17:

Хуралдааны дарга - “Салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн батлах тухай” (ГХУСАЗС3), “Олон нийтийн цагдаагийн тоо,

урамшууллын хэмжээг тогтоох тухай", "Урамшууллын хэмжээг тогтоох тухай" (Иргэний зөвлөл) илтгэлүүдийг аймгийн ИТХ-ын ГХУСАЗСЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Амархүү илтгэхийг мэдэгдэв.

"Салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн батлах тухай" (ГХУСАЗСЗ), "Олон нийтийн цагдаагийн тоо, урамшууллын хэмжээг тогтоох тухай", "Урамшууллын хэмжээг тогтоох тухай" (Иргэний зөвлөл) илтгэлүүдийг аймгийн ИТХ-ын ГХУСАЗСЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Амархүү илтгэв. 10 минут.

Хуралдааны дарга – Хэлэлцүүлсэн З асуудалтай холбогдуулан асуулт, хариулт явагдахыг мэдэгдэв.

### СОНССОН нь 15, 16, 17:

Хуралдааны дарга – Олон нийтийн цагдаагийн урамшууллыг Улаанбаатар хотод цалингийн сүлжээний ТТ-9-ын 1 дүгээр шатлалд дүйцүүлээд 641,363 төгрөгөөр олгох үүрэг болгосон тогтоол гараад Нийслэлд мөрдөж байгаа юм байна. Үүнийг үндэслээд Цагдаагийн байгууллагаас одоо авч байгаа 550,000 төгрөгөө 641,363 болгож нэмэгдүүлэх талаар хуралдаанаар хэлэлцүүлж өгөөч гэсэн хүсэлт ирсэн. Хурлаар хэлэлцүүлэх нь миний үүрэг учир хэлэлцүүлье. Орон нутгийн хувьд хүн амын тоо, хамрагдах хүрээ, ажлын ачаалал харьцангуй бага, тэгээд ч төсөв тооцоогоо боочихсон учир энэ удаад шийдвэрлэх боломжгүй. Хэрэв цаашид энэ асуудал яригдвал төсвийн тодотголоор орно гэдэг хариу өгсөн.

Б.Азжаргал (аймгийн Засаг дарга) – Олон нийтийн цагдаагийн урамшуулалт аймгийн ГХУСАЗСЗ-ийн төсөв дээр явдаг бил үү? 641,363 төгрөгөөр олгоход НДШ орох уу? сумдад хэдэн хүн байдаг юм.

Хуралдааны дарга – Тийм. 550,000 төгрөгөөр 21 хүнээ бодоод төсөвөө баталсан. НДШ бодогдоно.

Б.Амархүү (ГХУСАЗСЗ-ийн нарийн бичгийн дарга) – Дархан суманд 14, Замын хөдөлгөөний аюулгүй байдал дээр 3, Шарын гол суманд 2, Орхонд 1, Хонгорт 1 олон нийтийн цагдаа ажилладаг.

Б.Азжаргал (аймгийн Засаг дарга) – Одоо ямарч байсан хэлэлцүүлээд, батлагдсан төсвийнхөө хүрээнд явсан нь дээр байх.

П.Эрдэнэбат (аймгийн ИТХ-ын төлөөлөгч) – Аймгийн ИТХ-ын ГХУСАЗСЗ-ийн төсөв дээр Олон нийтийн цагдаагийн урамшуулалт багтсан байдаг. Жилийн эцэст төсвийн хэмнэлт гараад сайн ажилласан цагдаа нараа урамшуулах боломж байдаг. Өмнө ч өгч байсан.

Хуралдааны дарга – ГХУСэргийлэх ажилд оролцож байгаа байгууллага, хамт олон, хувь хүнийг жилийн эцэст үлдсэн хөрөнгөөрөө шагнаж урамшуулдаг.

Хуралдааны дарга – Өөр асуулт, санал гараагүй тул асуулт, саналыг таслах уу гэхэд төлөөлөгчид бүгд гар өргөж зөвшөөрснөөр асуулт, саналыг таслав.